



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАРУУН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-НИЙ 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/90/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Э.Бүгүнүтэй
Утас: 261740 Цахим хаяг: bugunutei@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Дундманхайдай аудит” ХХК
Захирал Ж.Бямбажав
Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

| | |
|---|----|
| 1. Аудитын санал дүгнэлт | 2 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан | 4 |
| 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан | 5 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 5 |
| 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл | 7 |
| 3. Аудитын тайлан | 8 |
| 3.1 Ерөнхий зүйл | 8 |
| 3.2 Дотоод хяналт | 8 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 8 |
| 3.4 Материаллаг байдал | 9 |
| 4. Санхүүгийн тайлангийн тодруулга | 9 |
| 4.1 Байгууллагын үйл ажиллагаа | 9 |
| 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин | 9 |
| 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого | 10 |
| 4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл | 12 |
| 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 13 |
| 5.1 Шилэн дансны мэдээлэл | 13 |
| 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 14 |
| 7. Аудитын илрүүлэлт | 14 |
| 7.1 Төлбөрийн акт | 14 |
| 7.2 Албан шаардлага | 15 |
| 7.3 Зөвлөмж | 15 |
| 8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 17 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТӨХК | Төрийн өмчит хувьцаат компани |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БАРУУН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ
СИСТЕМ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Д.ГАНХҮЛЭГ ТАНАА

2022.03.15 № 04/579
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баруун бүсийн эрчим хүчний системийн ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баруун бүсийн эрчим хүчний системийн ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Эрчим хүчний сайдын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/19 дугаар тушаалаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 37,946.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 37,998.9 сая төгрөгөөр, алдагдлыг 52.3 сая төгрөг байхаар баталсан байна. Эрчим хүчний сайдын 2021 оны А/169 дугаар тушаалаар нийт орлогыг 1,461.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,707.6 сая төгрөгөөр, алдагдлыг 246.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тодотгожээ.

Гүйцэтгэлээр 41,938.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 42,280.4 сая төгрөгийг зарцуулж, 341.5 сая төгрөгийн алдагдалтай тайлагнасан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компани 2021 онд 19 зорилтот ажлын хүрээнд 34 арга хэмжээг багцалж төлөвлөж, гүйцэтгэлийг 97.0 хувьтай гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | /төгрөгөөр/ | |
|-----------------|---|--------------------------|---------------------------|
| | | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 146,557,272.06 | 849,550,681.22 |
| 1.1.2 | Дансны авлага | 2,368,803,660.92 | 2,427,279,349.04 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 694,530.79 | 866,289,464.18 |
| 1.1.4 | Бусад авлага | 1,065,094,264.62 | 1,427,315,958.69 |
| 1.1.6 | Бараа материал | 1,285,873,982.25 | 1,609,625,106.70 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 161,791,051.58 | 171,755,919.12 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | 2,644,970,873.05 | 6,328,242,431.07 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 7,673,785,635.27 | 13,680,058,910.02 |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 83,070,896,521.54 | 88,577,747,680.40 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 2,950,304,329.30 | 2,933,597,974.78 |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | 0.00 | 12,163,153.85 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 86,021,200,850.84 | 91,523,508,809.02 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 93,694,986,486.11 | 105,203,567,719.04 |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 4,586,203,254.94 | 3,885,321,018.43 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 0.36 | 339,958.93 |
| 2.1.1.3 | Татварын өглөг | 423,581,885.85 | 1,416,353,088.15 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 58,333,530.90 | 53,107,672.43 |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | 4,229,759,460.84 | 4,442,482,850.07 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 195,998,059.18 | 97,792,137.30 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 182,043,540.09 | 87,707,835.09 |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 9,675,919,732.16 | 9,983,104,560.40 |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 38,382,189,216.61 | 39,169,002,771.90 |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | 291,593,520.51 | 323,948,839.11 |
| 2.1.2.6 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 38,673,782,737.12 | 39,492,951,611.01 |
| 2.2 | ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН | 48,349,702,469.28 | 49,476,056,171.41 |
| 2.3.1 | Өмч: а) төрийн | 55,201,072,729.44 | 55,201,072,729.44 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 5,892,490,095.45 | 6,509,599,095.45 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 8,988,227,460.92 | 19,094,651,807.99 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | (24,736,506,268.99) | (25,077,812,085.24) |
| 2.3.11 | ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 45,345,284,016.83 | 55,727,511,547.64 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 93,694,986,486.11 | 105,203,567,719.04 |

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | /төгрөгөөр/ | |
|---------------|------------------------------------|---------------------------|---------------------------|
| | | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 25,328,607,084.64 | 23,219,849,650.00 |
| 2 | Борлуулалтын өртөг | 31,442,942,286.52 | 32,813,008,410.85 |
| 3 | Нийт ашиг (алдагдал) | (6,114,335,201.88) | (9,593,158,760.85) |
| 5 | Хүүний орлого | 23,360,549.77 | 782,992.52 |
| 8 | Бусад орлого | 15,633,552,600.14 | 15,390,774,837.61 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 3,642,224,613.61 | 2,821,029,361.35 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 2,776,080,487.14 | 2,734,603,234.00 |

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ний 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-----------|---|---------------------------|-------------------------|
| 11 | Санхүүгийн зардал | 224,316,942.03 | 213,223,389.37 |
| 12 | Бусад зардал | 4,180,763,086.20 | 244,764,540.37 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 104,264,024.02 | (12,524,269.51) |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 0.00 | 2,150,000.00 |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | 0.00 | (87,842,209.22) |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | (1,176,543,156.93) | (313,437,934.54) |
| 19 | Орлогын татварын зардал | 48,469,664.40 | 28,045,090.69 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | (1,225,012,821.34) | (341,483,025.23) |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | (1,225,012,821.34) | (341,483,025.23) |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|--|--------------------------|-------------------------------------|---------------------------|----------------------------|---------------------------|
| 2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 54,067,984,610.95 | 5,763,630,095.45 | 3,303,386,744.82 | (28,137,074,608.23) | 34,997,926,842.99 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | 4,625,581,160.58 | 4,625,581,160.58 |
| Залруулсан үлдэгдэл | 54,067,984,610.95 | 5,763,630,095.45 | 3,303,386,744.82 | (23,511,493,447.65) | 39,623,508,003.57 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | (1,225,012,821.34) | (1,225,012,821.34) |
| Өмчид гарсан өөрчлөлт | 1,133,088,118.49 | | 5,684,840,716.10 | | 6,817,928,834.59 |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | 128,860,000.00 |
| 2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 55,201,072,729.44 | 5,892,490,095.45 | 8,988,227,460.92 | (24,736,506,268.99) | 45,345,284,016.82 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | 177,208.98 | 177,208.98 |
| Залруулсан үлдэгдэл | 55,201,072,729.44 | 5,892,490,095.45 | 8,988,227,460.92 | (24,736,329,060.01) | 45,345,461,225.80 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | (341,483,025.23) | (341,483,025.23) |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | 10,106,424,347.07 | | 10,106,424,347.07 |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | 617,109,000.00 | | | 617,109,000.00 |
| 2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 55,201,072,729.44 | 6,509,599,095.45 | 19,094,651,807.99 | (25,077,812,085.24) | 55,727,511,547.64 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| | | /төгрөгөөр/ | |
|---------------|---|---------------------------|---------------------------|
| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 29,998,167,509.54 | 37,659,612,061.56 |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 12,452,902,780.29 | 19,707,762,981.83 |
| | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | 494,950,819.42 | 212,779,188.08 |
| | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 27,863,940.00 | 30,994,022.00 |
| | Татаас, санхүүжилтийн орлого | 16,700,000,000.00 | 16,700,000,000.00 |
| | Бусад мөнгөн орлого | 322,449,969.83 | 1,008,075,869.65 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 23,701,350,768.01 | 35,501,984,730.51 |
| | Ажиллагчдад төлсөн | 4,351,644,901.28 | 4,833,503,168.01 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 1,145,371,561.56 | 1,459,895,236.60 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 10,845,589,821.13 | 18,272,362,128.97 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 2,142,971,594.21 | 6,038,501,460.62 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 276,483,390.94 | 256,266,824.00 |
| | Татварын байгууллагад төлсөн | 3,718,015,862.36 | 3,240,800,911.64 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | 31,595,066.00 | 14,957,208.00 |
| | Бусад мөнгөн зарлага | 1,189,678,570.53 | 1,385,697,792.67 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 6,296,816,741.53 | 2,157,627,331.05 |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 26,165,193.95 | 690,541,603.18 |
| | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 0.00 | 2,300,000.00 |
| | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 0.00 | 687,604,962.14 |
| | Хүлээн авсан хүүгийн орлого | 26,165,193.95 | 636,641.04 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 1,584,055,287.56 | 2,139,956,169.73 |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 1,207,140,229.75 | 1,071,157,260.81 |
| | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 26,789,454.55 | 19,984,071.49 |
| | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | 30,000,000.00 | 0.00 |
| | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 257,000.00 | 498,948.00 |
| | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 319,868,603.26 | 1,048,315,889.43 |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (1,557,890,093.61) | (1,449,414,566.55) |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 4,902,318,600.98 | 0.00 |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 4,900,000,000.00 | 0.00 |
| | Санхүүгийн түрээсний өглөгт төлсөн | 2,318,600.98 | 0.00 |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (4,902,318,600.98) | 0.00 |
| 4.1 | Валютын ханшийн зөрүү | | (5,219,355.32) |
| 4.2 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (163,391,953.06) | 702,993,409.18 |
| 5.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 309,949,225.12 | 146,557,272.04 |
| 5.2 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 146,557,272.06 | 849,550,681.22 |

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2020 оны гүйцэтгэл | 2021 оны | | | | |
|----|---|------------------------------|--------------------|------------|-----------|----------|---------|-------|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | |
| 1 | НИЙТ ЦЭХ | сая.кВтц | 187.5 | 204.3 | 220.7 | 16.4 | 8.0 | |
| | Үүнээс: Импортоор худалдаж авах ЦЭХ | сая.кВтц | 132.0 | 144.5 | 162.3 | 17.8 | 12.3 | |
| | ДУЦС-ын үйлдвэрлэх цахилгаан | сая.кВтц | 55.5 | 59.8 | 58.4 | -1.4 | -2.3 | |
| 2 | ДУЦС-ын дотоод хэрэгцээ | сая.кВтц | 4.5 | 4.4 | 4.7 | 0.3 | 5.8 | |
| | | хувь | 8.0 | 7.4 | 8.0 | 0.6 | 8.3 | |
| | Дамжуулахад | сая.кВтц | 51.1 | 55.4 | 53.7 | -1.6 | -2.9 | |
| | ОХУ-аас худалдан авах | сая.кВтц | 124.4 | 136.2 | 153.1 | 16.9 | 12.4 | |
| | БНХАУ-аас худалдан авах | сая.кВтц | 7.6 | 8.3 | 9.2 | 0.9 | 10.5 | |
| 3 | Дамжуулах ЦЭХ | сая.кВтц | 183.0 | 199.9 | 216.0 | 16.1 | 8.1 | |
| 4 | Дамжуулалт, түгээлтийн алдагдал | сая.кВтц | 33.3 | 34.0 | 36.0 | 2.0 | 5.9 | |
| | | хувь | 18.2 | 17.0 | 16.7 | -0.3 | -1.9 | |
| 5 | Борлуулах ЦЭХ | сая.кВтц | 149.7 | 165.9 | 180.0 | 14.1 | 8.5 | |
| 6 | Нийт орлого | сая.төг | 38,003.4 | 39,408.2 | 41,938.9 | 2,530.7 | 6.4 | |
| | Үүнээс: | Борлуулалтын орлого | сая.төг | 22,345.2 | 22,612.1 | 25,025.0 | 2,412.9 | 10.7 |
| | | Үйл ажиллагааны бусад орлого | сая.төг | 476.4 | 96.1 | 213.9 | 117.8 | 122.6 |
| | | Улсын төсвийн татаас | сая.төг | 15,181.8 | 16,700.0 | 16,700.0 | 0.0 | 0.0 |
| 7 | Нийт зардал | сая.төг | 39,228.5 | 39,706.5 | 42,280.4 | 2,573.9 | 6.5 | |
| | Үүнээс: | ЦЭХ-ний зардал | сая.төг | 18,175.8 | 20,831.4 | 23,219.3 | 2,387.9 | 11.5 |
| | | Үйл ажиллагааны зардал | сая.төг | 15,991.0 | 18,875.1 | 18,950.3 | 75.2 | 0.4 |
| | | Үйл ажиллагааны бус зардал | сая.төг | 5,061.7 | 0.0 | 110.8 | 110.8 | 0.0 |
| 8 | Татварын өмнөх ашиг / алдагдал | сая.төг | -1,225.1 | -298.3 | -341.5 | -43.2 | 14.5 | |
| | Татварын дараах ашиг/ алдагдал | сая.төг | -1,225.1 | -298.3 | -341.5 | -43.2 | 14.5 | |
| 9 | Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал | төгрөг | 1.0 | 1.01 | 1.01 | 0.0 | 0.1 | |
| 10 | Нийт авлага | сая.төг | 3,434.6 | 3,532.1 | 4,720.8 | 1,188.7 | 33.7 | |
| | Үүнээс: | Эрчим хүчний авлага | сая.төг | 3,365.9 | 3,377.7 | 4,563.5 | 1,185.8 | 35.1 |
| | | Бусад авлага | сая.төг | 68.7 | 154.4 | 157.3 | 2.9 | 1.9 |
| 11 | Нийт өглөг | сая.төг | 48,349.7 | 47,450.6 | 49,476.1 | 2,025.5 | 4.3 | |
| | Үүнээс: | Урт хугацаат өр төлбөр | сая.төг | 38,673.8 | 39,246.6 | 39,493.0 | 246.4 | 0.6 |
| | | Богино хугацаат өглөг | сая.төг | 9,675.9 | 8,204.0 | 9,983.1 | 1,779.1 | 21.7 |
| 12 | Ажиллагсдын тоо | тоо | 413.0 | 421.0 | 421.0 | 0.0 | 0.0 | |
| 13 | Нийт цалингийн сан | сая.төг | 5,397.0 | 5,597.0 | 5,367.2 | -229.8 | -4.1 | |
| 14 | Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалт | сая.төг | 2,378.3 | 2,351.1 | 2,178.9 | -172.3 | -7.3 | |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ний 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бөжөн аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад мөнгөн хөрөнгө, бараа материал, цалин, татвар, зардлын талаар холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Дундманхайдай аудит ХХК-ийн аудитор С.Батжаргал, аудиторын туслах З.Мандах нар гүйцэтгэж, захирал Ж.Бямбажав хянан удирдаж, чанарын хяналтыг менежер Б.Цэвэлмаа хэрэгжүүлсэн.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Дундманхайдай аудит ХХК-д 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 105 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Эрчим хүчний сайдын 2021 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн А/141 тоот тушаалаар баталсан “Шилэн дансны аудитыг хийж гүйцэтгэх удирдамж”-ийн дагуу “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд 2021 оны эхний хагас жилийн байдлаар дотоод аудитыг гүйцэтгэсэн байна.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь дотоод аудитын нэгжгүй, дотоод аудиторын мэргэжилтэн нь хараат бус, гүйцэтгэх удирдлагадаа ажлаа тайлагнадаг, дотоод хяналт хийсэн ажлын тайлангуудтай танилцсаны үндсэн дээр үр нөлөөг дунд гэж үнэлсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ний 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний нийт зардал 37,946.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 569.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ний зорилго нь цахилгаан эрчим хүч импортлох, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, цахилгаан эрчим хүч дамжуулах, хуваарилах цахилгаан эрчим хүч түгээж борлуулах, “Баруун бүс нутаг”-ийг эрчим хүчээр найдвартай хангаж, хэрэглэгчдийг дээдэлсэн соёлтой үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дотоодын эрчим хүчний эх үүсвэрээр баруун бүс нутгийг хангах, цахилгаан дамжуулах төвийн бүсийн системтэй зэрэгцэн ажиллах нэгдсэн системд шилжих гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨХК статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс Эрчим хүчний яам 70.0 хувь, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 30.0 хувь эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь 1995 оны 5 дугаар сарын 01-ний Эрчим хүч геологи уул уурхай яамны сайдын 90 дугаар тушаалыг үндэслэн байгуулагдсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор нийт 9 гишүүнтэйгээр томилсон байна.

Хувьцаа нийлүүлэгчийн хурлын 2021 оны 4 дүгээр сарын 27-ны 03 дугаар тогтоолоор компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 1 гишүүнийн сарын цалин, урамшуулал зардлыг 0.5 сая төгрөгөөр тогтоосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл

ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардалд нийт 76.9 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 70.4 сая төгрөгийн зардлыг зарцуулсан байна. Үүнд: Цалин, урамшууллын зардалд 61.9 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 8.1 сая төгрөг, албан томилолтын зардалд 0.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд компанийн хэмжээнд хөрөнгийн ашиглалтын байдалд үзлэг хийж үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглалтын байдлыг тогтоон 617.1 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэн, бүртгэлд тусгах арга хэмжээ авсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 207 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 124 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны 211 дугаар “Ковид-19 цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ний санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---------------------------------|---------------------|----------------------|---------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 146,557.3 | 849,550.7 | 702,993.4 |
| Дансны авлага | 2,368,803.7 | 2,427,279.3 | 58,475.7 |
| Татвар, НДШ-ийн авлага | 694.5 | 866,289.5 | 865,594.9 |
| Бусад авлага | 1,065,094.3 | 1,427,316.0 | 362,221.7 |
| Бараа материал | 1,285,874.0 | 1,609,625.1 | 323,751.1 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 161,791.1 | 171,755.9 | 9,964.9 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 2,644,970.9 | 6,328,242.4 | 3,683,271.6 |
| Үндсэн хөрөнгө | 83,070,896.5 | 88,577,747.7 | 5,506,851.2 |
| Биет бус хөрөнгө | 2,950,304.3 | 2,933,598.0 | (16,706.4) |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 0.0 | 12,163.2 | 12,163.2 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 93,694,986.5 | 105,203,567.7 | 11,508,581.2 |
| Дансны өглөг | 4,586,203.3 | 3,885,321.0 | (700,882.2) |
| Цалингийн өглөг | 0.0 | 340.0 | 340.0 |
| Татварын өглөг | 423,581.9 | 1,416,353.1 | 992,771.2 |
| НДШ-ийн өглөг | 58,333.5 | 53,107.7 | (5,225.9) |
| Хүүгийн өглөг | 4,229,759.5 | 4,442,482.9 | 212,723.4 |
| Урьдчилж орсон орлого | 195,998.1 | 97,792.1 | (98,205.9) |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 182,043.5 | 87,707.8 | (94,335.7) |
| Урт хугацаат зээл | 38,382,189.2 | 39,169,002.8 | 786,813.6 |
| Хойшлогдсон татварын өр | 291,593.5 | 323,948.8 | 32,355.3 |

| | | | |
|---------------------------------------|---------------------|----------------------|---------------------|
| Өмч: а) төрийн | 55,201,072.7 | 55,201,072.7 | 0.0 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 5,892,490.1 | 6,509,599.1 | 617,109.0 |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 8,988,227.5 | 19,094,651.8 | 10,106,424.3 |
| Хуримтлагдсан ашиг | (24,736,506.3) | (25,077,812.1) | (341,305.8) |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 93,694,986.5 | 105,203,567.7 | 11,508,581.2 |

Касс дах бэлэн мөнгө 7.8 сая төгрөг, арилжааны банкин дах долларын 2 харилцах дансанд 0.7 сая төгрөг, юанийн 3 харилцах дансанд 0.031 сая төгрөг, төгрөгийн 6 харилцах дансанд 841.0 сая төгрөг, нийт 841.7 сая төгрөг байна.

Авлагын дансны үлдэгдэлд ААНБОАТ-ын 7.3 сая, НӨАТ-ын 858.6 сая, цахилгааны 839.7 сая, ажилчдаас авах 13.9 сая, ДЦС-1 ТӨХК-аас авах 833.8 сая, ДЦС-2 ТӨХК-аас авах 623.7 сая, Засгийн газраас төлөх цахилгааны 1,242.5 сая, Эрчим хүчний яамнаас санхүүжүүлэх шөнийн тарифын хөнгөлөлтийн 145.0 сая, аж ахуйн нэгж байгууллагуудаас 156.2 сая, нийт 4,720.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Эрчим хүчний салбарын ДЦС-ууд болон Засгийн газраас төлөх цахилгааны авлага нь нийт авлагын 60.3 хувийг эзэлж байна. Тайлант онд “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний тухай” 2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу Засгийн газраас төлөх цахилгааны авлага 1,242.5 сая төгрөг, Эрчим хүчний яамнаас санхүүжүүлэх шөнийн тарифын хөнгөлөлтийн авлага 145.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлж байна.

Авлагын үлдэгдлээс төлөх хугацаандаа байгаа 3,887.0 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 670.8 сая төгрөгийн, 163.3 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Найдваргүй авлагыг хувийн жингийн аргаар тооцдог байна. Тайлант онд найдваргүй авлагын нөөц байгуулаагүй ба найдваргүй авлага данснаас хасагдуулга хийгдээгүй байна.

Тайлант онд БНХАУ-ын Алтай аймаг Чингэл сумын Улсын шугам сүлжээний Шиньжянь эрчим хүчний компаниас импортын эрчим хүчний цахилгаан нийлүүлэх урьдчилгаа төлбөрт 9.9 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 161.8 сая төгрөг нь 2020-2021 онд Хятад улсын цахилгаан нийлүүлэх барьцааны төлбөрийг урьдчилгаа дансанд байршуулсан үлдэгдэл тооцоо байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,609.6 сая төгрөг болж, 323.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны эцэст техник зохион байгуулалтын арга хэмжээний зардлаас 323.8 сая төгрөгийн бараа материал, сэлбэгийн худалдан авалт хийж, гэнэтийн аваар ослын үед бэлэн байлгах зорилгоор хангамжийн материал, сэлбэг хэрэгслийн нөөц бүрдүүлснээс шалтгаалсан байна. Тайлант онд худалдан авалтаар 2,694.7 сая төгрөгийн засвар үйлчилгээ, үндсэн сэлбэг хэрэгсэл, хөдөлмөр хамгаалал, хангамжийн материал бэлтгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд 367.9 сая төгрөгийн ашиглалтгүй, гамшгийн үед шаардлагатай үндсэн сэлбэгийн нөөц бүрдүүлсэн байна.

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 6,328.2 сая төгрөг болж, өмнөх оноос 3,683.3 сая төгрөгөөр өссөн нь Дэлхийн банкны санхүүжилтээр “Эрчим хүчний төсөл-2” төслийн хүрээнд Ховд аймгийн Мянгад суманд баригдаж байгаа нарны станцын дуусаагүй барилга бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгө худалдаж авсан 1,094.1 сая, ТӨБЗГ-ын 2021 оны 408 дугаар тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийг дахин шинэчлэн үнэлсэн 617.1 сая, ТӨБЗГ-ын 2021 оны 430 дугаар тогтоолын дагуу үнэ төлбөргүй хүлээн авсан 276.4 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны А-1/1491 дугаар тогтоолоор акталсан 55.9 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр хасагдсан байна.

Тайлант онд ТӨБЗГ-ын 2021 оны 272 дугаар тогтоолоор Ховд Цахилгаан түгээх сүлжээ ХХК-д Ховд аймгийн Мянгад суманд Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Эрчим хүчний төсөл-2” төслийн хөрөнгөөр 3,672.6 сая төгрөгийн, буцалтгүй тусламжаар 3,166.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнийг бүртгэлд тусгасан байна. Төсөл хөтөлбөрийн гүйцэтгэл 50 хувьтай байна.

Биет бус хөрөнгө тайлант үеийн хорогдол 16.7 сая төгрөгөөр буурчээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 9,983.1 сая төгрөг болж, 307.1 сая төгрөгөөр өссөн нь урт хугацаат зээлийн хүүгийн өглөг нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 39,169.0 сая төгрөг болж, 786.8 сая төгрөгөөр өссөн нь Ховд аймгийн Мянгад суманд баригдаж буй нарны станцын дуусаагүй барилгын зээлийн санхүүжилт нэмэгдсэн, зээлийн төлбөрийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байгаагаас шалтгаалсан байна. Баруун бүсийн эрчим хүчний станцуудад 4 төсөл, хөтөлбөрийн нэгжээс хэрэгжүүлж байгаа төслийн үр дүнд бий болсон урт хугацаат зээлийн дүн 39,169.0 сая төгрөг байна.

Хүснэгт 2. Урт хугацаат зээлийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

| Д/д | Төсөл, арга хэмжээ | Зээлийн үлдэгдэл сая төгрөг /2020.12.31/ | Хөрөнгө оруулагч | Төсөл хэрэгжиж хугацаа | Төслийн зорилго |
|-----|--------------------------|--|------------------|------------------------|--|
| 1 | Эрчим хүчний төсөл- 2 | 3,431.6 | Дэлхийн банк | 2019 -2030 | Ховд Мянгад суманд Нарны станц барих |
| 2 | Эрчим хүчний төсөл | 31,940.7 | Хятадын банк | 2012.12.27-2026.04.01 | Дөргөний усан цахилгаан станц барих төсөл |
| 3 | Алдагдал бууруулах төсөл | 1,752.6 | Дэлхийн банк | 2012.09.10-2026.04.01 | Айл өрхийн цахилгааны алдагдлыг бууруулах зорилгоор хийгдсэн төсөл |
| 4 | Алдагдал бууруулах төсөл | 2,044.1 | Дэлхийн банк | 2012.09.10-2026.04.01 | Айл өрхийн цахилгааны алдагдлыг бууруулах зорилгоор хийгдсэн төсөл |
| | Дүн | 39,169.0 | | | |

Өмнөх үеийн хуримтлагдсан алдагдал 25,077.8 сая төгрөг болж 341.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн ашгаас шалтгаалсан байна.

Тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйл ажиллагааны ба үйл ажиллагааны бус зардлын хүлээн зөвшөөрөлт, үнэлгээг аккрузал сууриар тайлагнах, хэмжих боломжтой үед хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж 3 ангилсан байна. Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт худалдаж авсан цахилгаан эрчим хүч, хангах үйл ажиллагаатай холбогдон гарсан тогтмол болон хувьсах зардлуудыг хамруулсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ний үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/19 дугаар тушаалаар Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 37,946.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 37,998.9 сая төгрөгөөр, 52.3 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,421.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Эрчим хүчний сайдын 2021 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн А/169 дугаар тушаалаар нийт орлогыг 1,461.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,707.6 сая төгрөгөөр, алдагдлыг 246.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тодотгожээ

Гүйцэтгэлээр 41,938.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 42,280.4 сая төгрөгийг зарцуулж, 341.5 сая төгрөгийн алдагдалтай тайлагнасан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 41,938.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 2,530.7 сая төгрөг буюу 6.4 хувиар давсан нь борлуулсан цахилгаан эрчим хүч 14.3 сая кВтц-аар нэмэгдэж, эрчим хүчний борлуулалтын орлого өссөнөөс шалтгаалсан байна. Нийт зардлын гүйцэтгэл 42,280.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,573.9 сая төгрөг буюу 6.5 хувиар илүү байна. Энэ нь ОХУ-аас худалдан авах импортын эрчим хүчний үнэ болон импортын эрчим хүчний хэмжээ 17.8 сая кВт.ц-аар нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 75 нэр төрлийн бараа ажил үйлчилгээ, засвар үйлчилгээний зардалд 2,178.9 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд алдагдал 341.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 43.2 сая төгрөгөөр илүү байгаа нь үндсэн сэлбэг хэрэгсэл, шатахууны үнэ нэмэгдэж, зардал өссөн нь нөлөөлсөн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацааны цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш худалдан авалтыг шилэн дансанд байршуулсан эсэхийг тулган шалгахад Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь 6.6 сая төгрөгийн катаны худалдан авалт, 3.2 сая төгрөгийн ашиглалтын зардал, Дөргөн УЦС ХХК нь 131.7 сая төгрөгийн бараа материалын худалдан авалт, Ховд ЦТС ХХК нь 15.7 сая төгрөгийн кабелийн худалдан авалт, Увс ЦТС ХХК нь УАЗ-Фургон автомашин 49.9 сая төгрөгөөр худалдан авсныг шилэн дансанд 34.2 сая төгрөгөөр худалдан авснаар 15.7 сая төгрөг зөрүүтэй мэдээлсэн, нийт 172.9 сая төгрөгийн худалдан авалтыг шилэн дансанд мэдээлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтай тус тус нийцэхгүй, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 23,953.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 566.3 сая төгрөгийг залруулж, 23,386.7 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 0.3 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.8 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 12.6 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 315.9 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгснөөс акт 100 хувь, албан шаардлага 66.6 хувь, зөвлөмж.100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|-----------------|---------------------|--------------|-----------|--------------|-------|-----|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 2 | 0.8 | 2 | 0.8 | | - | 100 |
| Албан шаардлага | 3 | 12.6 | 2 | 12.6 | 1 | - | 66.6 |
| Зөвлөмж | 7 | 315.9 | 7 | 315.9 | | - | 100 |
| Нийт дүн | 12 | 329.3 | 11 | 329.3 | | - | 91.6 |

/мянган төгрөг/

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлт 91.6 хувийн хэрэгжилттэй байна.

7. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 331.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 35.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 289.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 331.7 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 569.2 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхөөр шийдвэрлэв.

7.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь “Дэвжих танан эрдэнэ” ХХК-аас лист төмөр худалдан авахдаа бусад байгууллагаас худалдан авсан ижил төрлийн материалын дундаж үнээс 0.3 сая төгрөг, Ховд ЦТС ХХК нь засвар үйлчилгээнд зориулж автомашин худалдан авахдаа батлагдсан төлөвлөгөөнөөс 0.4 сая төгрөг нийт 0.7 сая төгрөгийг илүү үнээр худалдан авалт хийн хэтрүүлэн зарцуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.”, 46.1.4--д “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;”, 46.1.5-д энэ хуулийн 7.6-д “зааснаас бусад бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх;”, 46.1.6-д “гүйцэтгэгчийн

гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах,” гэсэн заалтуудтай нийцээгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Тайлант хугацааны эцэст татварын албанд бүртгэлтэй хуримтлагдсан суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын 6.6 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.”Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:”14.4.2.”бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;”, 18.1.”Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай нийцээгүй, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

7.2 Албан шаардлага

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь 15.0 сая, Ховд ЦТС ХХК нь 9.8 сая нийт 24.8 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Байгууллагын 2021 оны зорилтот түвшний төлөвлөгөөнд батлагдсан халаалт цахилгааны зардлыг Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК 7.9 сая төгрөгөөр, Ховд ЦТС ХХК 2.6 сая, нийт 10.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Засгийн газрын 2021 он 2 дугаар сарын 17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.8.-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах,” гэсэн заалттай нийцээгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

7.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь 59.0 сая, Дөргөн УЦС ХХК 75.2 сая, нийт 134.2 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалт, НБББББ-ийн 2.6.9-д “Өртөг, зардлын бүртгэлийн бодлого”-ыг мөрдөөгүй ба “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүй батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Мөнгөн хөрөнгийн данснаас шилжүүлсэн төлбөр тооцоог тооцооны дансаар дамжуулан бүртгэж байх.

2. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК 74.4 сая, Дөргөн УЦС ХХК 0.5 сая, Увс ЦТС ХХК нь 67.7 сая, нийт 142.6 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 "Бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно" гэсэн заалттай нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Бараа ажил, үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ и-баримтыг бүрдүүлж байх, татварын цахим системд худалдан авалтын и-баримтын шивэлтийг хянах.

3. Бараа материалын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК 6.5 сая, Увс ЦТС ХХК 4.2 сая төгрөгийн бараа материалыг батлагдсан төлөвлөгөөнөөс илүү хэмжээгээр худалдан авсан, Ховд ЦТС ХХК-ийн бараа материалын үлдэгдэлд 1.4 сая төгрөгийн ашиглагдаагүй принтерийн хор бүртгэлтэй, нийт 12.1 сая төгрөгийн бараа материал нөөцөлсөн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэсэн заалттай нийцээгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж

Бараа материалын бэлтгэхдээ худалдан авалтын төлөвлөгөөг мөрдөн, дотоод аудитор хяналт тавих ба ашиглалтгүй бараа материал бэлтгэн нөөцлөхгүй байх

4. Цалингийн данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 2 албан хаагчийн цалингаас нийт 0.2 сая төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгаж, гарт олгох цалинг илүү олгосон байна. Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ" гэсэн заалттай нийцээгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын ногдуулалт хийхдээ холбогдох хуульд заасан нийтлэг журмыг баримтлах, хувь хүний орлогын албан татварын төлөлтийн тайланг үнэн зөв тайлагнаж тооцоог тулган баталгаажуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---------------------------------|--|------------------------|---|---|--------------------------|----------|-----------|-----|-----|---------|-----------------|----------|-------------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК | АХГ-2022/90/НА-СТА-ТӨА | Тайлант хугацаанд Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь Дэвжих танан эрдэнэ ХХК-аас лист төмөр худалдан авахдаа бусад байгууллагаас худалдан авсан ижил төрлийн материалын дундаж үнээс 0.3 сая төгрөгийн илүү үнээр, Ховд ЦТС ХХК нь засвар үйлчилгээнд зориулж автомашин худалдан авахдаа батлагдсан төлөвлөгөөнөөс 0.4 сая төгрөгийн илүү үнээр тус тус худалдан авалт хийж нийт 0.7 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан. | Төлбөрийн акт акт тогтоов | 1 | 660.0 | | | 1 | 660.0 | | | | | | |
| 2 | Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК | АХГ-2022/90/НА-СТА-ТӨА | Тайлант хугацааны татварын албанд бүртгэлтэй хуримтлагдсан 6.6 сая төгрөгийн суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй. | Төлбөрийн акт акт тогтоов | 1 | 6,664.5 | | | 1 | 6,664.5 | | | | | | |
| 3 | Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК | АХГ-2022/90/НА-СТА-ТӨА | Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь өмнөх оны 6.9 сая төгрөгийн авлага, тайлант онд үүссэн хувь хүнээс авах 8.1 сая төгрөгийн авлага, Ховд ЦТС ХХК нь өмнөх оны ажиллагсадтай холбоотой 5.8 сая төгрөгийн, хувь хүнээс авах 1.5 сая төгрөгийн, тайлант онд үүссэн 2.5 сая төгрөгийн авлага, нийт 24.8 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй. | Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, авлагыг барагдуулах арга хэмжээг авах | 1 | 24,816.6 | | | | | 1 | 24,816.6 | | | | |
| 4 | Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК | АХГ-2022/90/НА-СТА-ТӨА | Байгууллагын 2021 оны зорилтот түвшний батлагдсан төлөвлөгөөг тайлант оны гүйцэтгэлтэй тулган шалгахад Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь халаалт цахилгааны зардлыг 7.9 сая төгрөгөөр, Ховд ЦТС ХХК нь халаалт цахилгааны зардлыг 2.6 сая төгрөгөөр, нийт 10.5 сая төгрөгийн | Зардлыг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, | 1 | 10,548.8 | | | | | 1 | 10,548.8 | | | | |

| Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал | | | | | | | | | | | | | | | |
|---|--|-----------------------|--|--|----------|------------------|--|----------|----------------|----------|-----------------|----------|------------------|----------|------------------|
| 1 | Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК | АХГ-2022/90/НА-СТА-ТӨ | Тайлант хугацааны цалингаас бусад 5 саяас дээш худалдан авалтыг шилэн дансанд байршуулсан эсэхийг тулган шалгахад Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь 6.6 сая төгрөгийн катаны худалдан авалт, 3.2 сая төгрөгийн ашиглалтын зардал, Дөргөн УЦС ХХК нь 131.0 сая төгрөгийн бараа материалын худалдан авалт, Ховд ЦТС ХХК нь 15.7 сая төгрөгийн кабелийн худалдан авалт, нийт 156.5 сая төгрөгийн худалдан авалтыг шилэн дансанд мэдээлээгүй, Увс ЦТС ХХК нь УАЗ-Фургон автомашин 49.9 сая төгрөгөөр худалдан авсныг шилэн дансанд 34.2 сая төгрөгөөр худалдан авснаар зөрүүтэй мэдээлсэн. | Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосон хугацаанд, ил тод, шуурхай мэдээлэх | 1 | 172,900.0 | | | | | | 1 | 172,900.0 | | |
| | | | ДҮН | | 1 | 172,900.0 | | | | | | 1 | 172,900.0 | | |
| | | | НИЙТ ДҮН | | 9 | 504,593.9 | | 2 | 7,324.5 | 2 | 35,365.4 | 1 | 172,900.0 | 4 | 289,004.0 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 421/АОН50055

Улаанбаатар хот

АХГ-2022/90/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын 2021 оны зорилтот түвшний төлөвлөгөөнд батлагдсан халаалт цахилгааны зардлыг Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК 7,900,000.00 төгрөгөөр, Ховд Цахилгаан түгээх сүлжээ ХХК нь халаалт цахилгааны зардлыг 2,600,000.00 төгрөгөөр, нийт 10,500,000.00 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.8 “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах,” гэсэн заалттай нийцээгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зардлыг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, үр дүнг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Ганхүлэг, Нягтлан бодогч Н.Отгонтунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ж.БЯМБАЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

10.10.10.20-Bichig_Khereg/Alban_Shaardлага/2022/0315_Auditin_2_Gazar-104.Docx

0010801192



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 422/А0150055
АХГ-2022/90/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд цалингаас бусад 5,000,000.00 төгрөгөөс дээш худалдан авалтыг шилэн дансанд байршуулсан эсэхийг тулган шалгахад Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь 6,600,000.00 төгрөгийн катаны худалдан авалт, 3,200,000.00 төгрөгийн ашиглалтын зардал, Дөргөний Усан цахилгаан станц ХХК нь 131,700,000.00 төгрөгийн бараа материал, Ховд Цахилгаан түгээх сүлжээ ХХК нь 15,700,000.00 төгрөгийн кабель, Увс Цахилгаан түгээх сүлжээ ХХК нь УАЗ-Фургон автомашин 49,900,000.00 төгрөгөөр худалдан авсныг шилэн дансанд 34,200,000.00 төгрөгөөр худалдан авснаар 15,700,000.00 төгрөг зөрүүтэй мэдээлсэн, нийт 172,900,000.00 төгрөгийн худалдан авалтыг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтай тус тус нийцэхгүй, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг мөрдөж, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн захирал Д.Ганхүлэг, Ерөнхий нягтлан бодогч Н.Отгонтунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЕР ДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ж.БЯМБАЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2022\0315 Auditin 2 Газар-105.Docx

0010801194



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 423/А.0150053
АХГ-2022/901НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Баруун бүс эрчим хүчний систем ТӨХК нь өмнөх оны 6,900,000.00 төгрөгийн авлага, тайлант онд үүссэн хувь хүнээс авах 8,100,000.00 төгрөгийн авлага, Ховд Цахилгаан түгээх сүлжээ ХХК нь өмнөх оны ажиллагсадтай холбоотой 5,800,000.00 төгрөгийн, хувь хүнээс авах 1,500,000.00 төгрөгийн, тайлант онд үүссэн 2,500,000.00 төгрөгийн авлага, нийт 24,800,000.00 төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, Санхүүгийн тайлангийн "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Авлагыг барагдуулах арга хэмжээг авч албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн захирал Д.Ганхүлэг, Ерөнхий нягтлан бодогч Н.Отгонтунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В.Р.У* Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР *Ц.Хосжаргал* Ц.ХОСЖАРГАЛ
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ *Ж.Бямбажав* Ж.БЯМБАЖАВ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 89/А0150055

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд Баруун бүс эрчим хүчний систем ТӨХК нь Дэвжих танан эрдэнэ ХХК-аас лист төмөр худалдан авахдаа бусад байгууллагаас худалдан авсан ижил төрлийн материалын дундаж үнээс 300,000.00 төгрөгийн илүү үнээр авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4.2 “төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж Төрийн өмчийн хороонд оруулах;” 4.3 “олгогдсон эрх хэмжээнийхээ дотор төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэнтэй заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Худалдан авсан ижил төрлийн материалын дундаж үнээс илүү үнээр худалдаж авсан материалын үнэ 300,000.00 /гурван зуун мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Ганхүлэг, Нягтлан бодогч Н.Отгонтунгалаг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Ж.БЯМБАЖАВ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 90/А0150055
АХГ-2022/90/НА-СТА-ТӨА
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ний 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ховд Цахилгаан түгээх сүлжээ ХХК нь засвар үйлчилгээнд зориулж автомашин худалдан авахдаа батлагдсан төлөвлөгөөнөөс 360,000.00/гурван зуун жаран мянган/ төгрөгөөр илүү үнээр худалдан авалтыг хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.1 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.", 46.1.4 "худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах;", 46.1.5 энэ хуулийн 7.6-д зааснаас бусад бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх; 46.1.6 "гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах;" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Худалдан авах төлөвлөгөөнөөс хэтрүүлж зарцуулсан 360,000.00 /гурван зуун жаран мянган/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн гүйцэтгэх захирал С.Гантөмөр, Нягтлан бодогч Н.Шинэжил нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ж.БЯМБАЖАВ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 91/А050055
АХГ-2022/90/НБ-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын 6,664,530.96 төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:"14.4.2."бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" 18.1."Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын 6,664,530.96 /Зургаан сая зургаан зуун жаран дөрвөн мянга таван зуун гучин төгрөг 96 мөнгө/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Ганхүлэг, Нягтлан бодогч Н.Отгонтунгалаг нар хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
АУДИТЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
ДУНДМАНХАНДАЙ АУДИТ ХХК Ж.БЯМБАЖАВ
АУДИТОР



